



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/Н/44

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын "Хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын норматив батлах тухай" 1999 оны 198 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Их Хурлын ажлын албанаас батлагдсан хөтөлбөрийн дагуу 2020 оны 10 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Уянга сумдад хууль тогтоомж сурталчилах, иргэд, олон нийттэй хийх уулзалтыг зохион байгуулсан зардалд 6.613.299 (зургаан сая зургаан зуун арван гурван мянга хоёр зуун ерэн ес) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011101041